



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 392  
танай -ы № -т

**ГХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН 7  
ЗАСАГ ДАРГА Г.АДЬЯАБИЛЭГТ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг 1 төлбөрийн акт, 1 зөвлөмжийн хамт хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 30 хоногийн дотор, акт, зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт 45 хуудастай.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэntий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2025/006/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Улаанбаатар хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Ц.Хатанболд  
Утас: 91117325

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага түүний үйл ажиллагaa .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бodoх бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	11
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.4.2 Авлага .....	12
3.4.3 Бараа материал.....	13
3.4.4 Үндсэн хөрөнгө .....	13
3.4.5 Засгийн газрын хувь оролцоо .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.5 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
5.1 Төлбөрийн акт .....	22
5.2 Албан шаардлага.....	22
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 386

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Өөрчлөлтгүй дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Бор-Өндөр сумын төвлөрүүлэн захирагч нь 2024 онд 7,202,379.3 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 8,190,935.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 988,556.0 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар давуулан биелүүлж аймгийн төсөвт 3,604,953.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 365,156.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6,483.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 356,673.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх үүрэгтэй боловч 54.5.4 "Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, 232520380

түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/ тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд дараагийн аудитад санхүүгийн тайлангийн бүрдлийг бүрэн хангах шаардлагатай байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,133,880.00	3,413,321.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,823,832.70	1,829,495.20
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	1,104,017.30	1,065,281.90
34	УРЬДЧИЛГАА	47,760.30	144,750.00
35	БАРАА МАТЕРИАЛ	158,269.70	373,794.40
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,856,987.80	8,431,724.20
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
37100	Урт хугацаат хадгаламж	-	-
37200	Үнэт цаас	-	-
37300	Урт хугацаат зээл	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,856,987.80	8,431,724.20
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	9,221,740.80	7,796,491.20
39300	Биет бус хөрөнгө	635,247.00	635,233.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,990,867.80	11,845,045.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,703.50	47,523.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,703.50	47,523.50
41100	Богино хугацаат үнэт цаас	-	-
41200	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
41300	Өглөг	6,703.50	47,523.50
41400	Урьдчилж орсон орлого	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42100	Урт хугацаат үнэт цаас	-	-
42200	Урт хугацаат зээл	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,984,164.30	11,797,522.20
51	Засгийн газрын хувь оролцоо	12,984,164.30	11,797,522.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,375,949.90	1,282,789.30
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	93,160.60
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	-	-
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	-	-
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	3,903,790.60	2,717,148.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,704,423.80	7,704,423.80
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
52	Хяналтын бус хувь оролцоо	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,990,867.80	11,845,045.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,488,677.80	16,420,973.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	6,310,408.20	7,769,596.70
110	Орлогын албан татвар	5,759,786.30	7,174,635.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	5,759,786.30	7,174,635.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	-	-
1103	ААН-ын орлогын албан татвар	-	-
1104	Зарим бутээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	-	-
113	Хөрөнгийн албан татвар	306,460.10	293,299.80
114	Нэмэгдсэн өргтийн албан татвар	-	-
115	Онцгой албан татвар	-	-
116	Тусгай зориулалтын орлого	-	-
117	Гадаад үйл ажиллагааны орлого	-	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	244,161.90	301,661.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,269,393.20	1,186,956.50
120	Нийтлэг татварын бус орлого	1,269,393.20	1,186,956.50
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусламжийн орлого	-	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
124	Зээлийн орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,908,876.40	7,464,420.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,364,843.90	15,954,524.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,362,857.80	15,954,524.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,164,043.40	6,776,178.50
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	1,455,494.20	2,364,315.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,797.90	276,947.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,945.80	1,233,145.90
2104	Хангамж, бараа материалын зардал	248,031.70	376,390.90
2105	Нормативт зардал	84,691.80	43,762.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,286.50	307,166.30
2107	Томилолт, зочны зардал	45,756.00	42,456.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	740,607.90	225,311.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,220,431.60	1,906,682.10
211	XYY	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,198,814.40	9,178,345.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,986.10	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,123,833.90	466,449.80
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	706,147.40	540,850.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,417,686.50	(74,400.50)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,583,432.90	-	11,583,432.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(16,955.10)	-	(16,955.10)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,566,477.80	-	11,566,477.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланц хулээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилэлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	1,417,686.50	-	1,417,686.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,984,164.30	-	12,984,164.30
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,984,164.30	-	12,984,164.30
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,112,241.60)	-	(1,112,241.60)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,871,922.60	-	11,871,922.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланц хулээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилэлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	(74,400.50)	-	(74,400.50)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,797,522.20	-	11,797,522.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,465,820.40	16,010,556.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	6,310,408.20	7,769,596.70
110	Орлогын албан татвар	5,759,786.30	7,174,635.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	5,759,786.30	7,174,635.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	-	-
1103	ААН-ын орлогын албан татвар	-	-
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн ёсөлтийн албан татвар	-	-
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	-	-
113	Хөрөнгийн албан татвар	306,460.10	293,299.80
114	Нэмэгдсэн ертгийн албан татвар	-	-
115	Онцгой албан татвар	-	-
116	Тусгай зориулалтын орлого	-	-
117	Гадаад үйл ажиллагааны орлого	-	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	244,161.90	301,661.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	99,971.40	128,450.50
1181	Газрын төлбөр	144,190.40	173,211.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	-
1183	Бусад татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	506,393.00	767,111.50
120	Нийтлэг татварын бус орлого	506,393.00	767,111.50
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусlamжийн орлого	-	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,649,019.20	7,473,848.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,268,200.10	15,229,425.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,268,200.10	15,229,425.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,050,574.00	5,911,576.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	921,943.70	1,762,242.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,819.10	172,601.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,668.80	1,180,004.50
2104	Хангамж, бараа материалын зардал	133,430.80	150,907.60
2105	Нормативт зардал	50,529.20	38,764.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,690.00	307,431.10
2107	Томилолт, зочны зардал	45,976.00	42,574.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,560,802.40	1,263,899.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,714.10	993,150.80
211	XYY	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,217,626.10	9,317,848.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,197,620.30	781,131.70
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	728,461.80	775,469.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	728,461.80	775,469.20
2200	Дотоод эх үүсвэрээр	728,461.80	775,469.20
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(728,461.80)	(775,469.20)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(381,000.00)	-
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	381,000.00	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-

25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,088,158.50	5,662.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	735,674.20	1,823,832.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,823,832.70	1,829,495.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,525,311.2	5,538,611.0
УРСГАЛ ЗАРДАЛ	5,276,048.3	4,950,764.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,179,792.8	4,860,327.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,488,581.8	1,397,268.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,209.6	130,917.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,185,283.5	1,159,149.2
Хангамж, бараа материалын зардал	85,227.3	81,394.4
Нормативт зардал	1,807.1	922.0
Эд хогшил, ургал засварын зардал	403,552.8	402,370.6
Томилолт, зочны зардал	32,825.0	29,614.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,219,122.3	1,119,873.9
Бараа үйлчилгээний бусад зардал	617,183.4	538,817.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,255.5	90,436.9
Засгийн газрын ургал шилжүүлэг	37,000.0	37,000.0
Бусад ургал шилжүүлэг	59,255.5	53,436.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	886,099.2	587,896.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	363,163.7	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,525,311.2	5,858,496.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,845,191.4	5,529,701.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	680,119.8	328,795.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	264,848.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	585,101.9

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>812,622.40</b>
<b>21 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>812,622.40</b>
<b>210 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>673,669.80</b>
<b>2104 Хангамж бараа материалын зардал</b>	<b>1,293.00</b>
<b>2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>182,269.60</b>
<b>2109 Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>490,107.10</b>
<b>213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>138,952.60</b>
<b>2133 Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>138,952.60</b>
<b>I ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>812,622.40</b>
<b>1311 Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>812,622.40</b>

Хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд "сум нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн нэгж мөн" гэж сумын Засаг даргын эрх зүйн харилцаанд оролцох байдлыг тодорхойлжээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хуульд "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлгнах эрх бүхий этгээдийг" гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 5.4.-д Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьялагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

- ✓ 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх
- ✓ 15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бodoх бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзэв.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бodoх бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бodoх бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,145,822.2 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар буурсан байна.

### Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,823,832.70	1,829,495.22	5,662.52
Авлага	1,104,017.28	1,065,281.89	(38,735.39)
Урьдчилгаа	47,760.33	144,750.00	96,989.67
Бараа материал	158,269.68	373,794.36	215,524.69
Үндсэн хөрөнгө	9,856,987.81	8,431,724.15	(1,425,263.66)
Нийт хөрөнгө	12,990,867.79	11,845,045.63	(1,145,822.17)
Өр төлбөр	6,703.54	47,523.47	40,819.94
Засгийн газрын оруулсан капитал	1,375,949.91	1,375,949.91	-
Хуримтлагдсан үр дүн	3,903,790.58	2,717,148.47	(1,186,642.11)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,704,423.77	7,704,423.77	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,990,867.79	11,845,045.63	(1,145,822.17)

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,829,495.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,662.5 мянган төгрөгөөр өссөн байна.

### Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,352,567.73	1,825,312.55	472,744.82
Төрийн сангийн харилцах	1,352,415.50	1,825,276.72	472,861.22
Арилжааны банк дахь харилцах	152.23	35.83	(116.40)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
Замд явaa мөнгөн хөрөнгө	471,264.97	4,182.67	(467,082.30)
Дүн	1,823,832.70	1,829,495.22	5,662.52

Эх сурвалж: Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн өрөнхий орлогын дансны үлдэгдэл 1,240,174.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 339,264.0 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 242,037.9 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангийн үлдэгдэл 3,800.0 мянган төгрөг, арилжааны банкны дансны үлдэгдэлд Цэгцүүлэн дом ӨЭМТ-ийн 35.8 мянган төгрөг байна.

#### 3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 1,065,281.9 мянган төгрөг болж өмнөх оноос 38,735.4 мянган төгрөгөөр буурсан байна.

### Хүснэгт №3.1 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	32.62	1,662.43	1,629.80
Төлбөртэй үйлчилгээний авлага	127,837.67	130,279.41	2,441.74
Зээлийн хүүгийн авлага	36,082.03	19,579.01	(16,503.02)
Бусад авлага	122,756.76	228,164.40	105,407.64
Хувь хүмүүст олгосон зээл	817,308.20	685,596.64	(131,711.55)
Дүн	1,104,017.28	1,065,281.89	(38,735.39)

**Эх сурвалж: Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан**

Авлага дансны үлдэгдэл Засаг даргын тамгын газрын нэмэлт дансны үлдэгдэл төвлөрүүлснийг авлаггаар бүртгэсэн 141,523.7 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажиллагсадтай холбогдсон авлага 1,833.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн байгууллагаас авах авлага 78,646.9 мянган төгрөг, Хот тохижилтын газрын төлбөртэй үйлчилгээний авлага 96,552.9 мянган төгрөг, Цэгцүүлэн дом ӨЭМТ-ийн татаас санхүүжилтийн авлага 41,548.9 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 707,175.7 мянган төгрөг байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 144,750.0 мянган төгрөг болж өмнөх оноос 96,989.7 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №3.2 Урьдчилгаа дансны үлдэгдэл**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өсөлт (+), бууралт (-)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	47,340.33	144,250.00	96,909.67
Цалингийн урьдчилгаа	420.00	500.00	80.00
<b>Дүн</b>	<b>47,760.33</b>	<b>144,750.00</b>	<b>96,989.67</b>

**Эх сурвалж: Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан**

Урьдчилгаа дансны үлдэгдэл Засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд хийгдсэн арга хэмжээг урьдчилгаа тооцоогоор бүртгэсэн 144,250.0 мянган төгрөг, цалингийн урьдчилгаанд хот тохижилтын газарт 500.0 мянган төгрөг байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 373,794.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 215,524.7 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өсөлт (+), бууралт (-)
Түүхий эд материал	28,334.87	40,637.27	12,302.40
Тусгай зориулалтын материал	4,759.00	14,698.00	9,939.00
Эм боох материал	23,575.87	25,939.27	2,363.40
Хангамжийн материал	129,934.81	333,157.09	203,222.28
Бичиг хэргийн материал	13,546.71	19,698.71	6,152.00
Аж ахуйн материал	93,819.29	275,674.93	181,855.63
Сэлбэг хэрэгсэл	-	9,456.45	9,456.45
Тулш, шатах тослох материал	239.80	-	(239.80)
Барилгын засварын материал	12,329.00	18,327.00	5,998.00
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	-	-	-
Мал амьтад	10,000.00	10,000.00	-
<b>Дүн</b>	<b>158,269.68</b>	<b>373,794.36</b>	<b>215,524.69</b>

**Эх сурвалж: Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан**

Тайлант онд 845,452.4 мянган төгрөгийн бараа материалыг орлого авснаас 694,450.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 151,001.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Нийт 629,927.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 8,431,724.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,425,263.7 мянган төгрөгөөр өссөн байна.

## Хүснэгт №5. Үндсэн хөрөнгө

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Биет хөрөнгө	9,221,740.81	7,796,491.15	(1,425,249.66)
Барилга, байгууламж, орон сууц	7,037,671.75	6,388,107.93	(649,563.82)
Авто-тээврийн хэрэгсэл	682,862.84	921,167.60	238,304.76
Машин тоног төхөөрөмж(компьютер)	187,425.15	266,320.35	78,895.20
Тавилга, аж ахуйн эд хогшил	52,337.55	59,777.37	7,439.82
Зам гүүр барилга байгууламж	1,510.31	1,132.73	(377.58)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	31,600.00	31,600.00	-
Бусад үндсэн хөрөнгө	1,228,333.21	128,385.17	(1,099,948.04)
Ном	-	-	-
Биет бус хөрөнгө	635,247.00	635,233.00	(14.00)
Програм хангамж	14.00	-	(14.00)
Бусад биет бус хөрөнгө	635,233.00	635,233.00	-
Дун	9,856,987.81	8,431,724.15	(1,425,263.66)

Эх сургалж: Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 319,872.8 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 424,326.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн задаргааг байгууллагаар ангилбал Бор-Өндөр сумын ЗДТГ-т 394,617.3 мянган төгрөг, Цэпүүлэн дом ӨЭМТ-д 29,708.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.

### **3.4.5 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны 1,375,949.9 мянган төгрөгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

## **Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо**

### /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	1,375,949.9	1,375,949.9	-
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,375,949.9	1,375,949.9	-
<b>Хүримтлагдсан үр дүн</b>	<b>3,903,790.6</b>	<b>2,717,148.5</b>	<b>(1,186,642.1)</b>
Өмнөх үеийн үр дүн	3,903,790.6	2,791,549.0	(1,112,241.6)
Тайлант үеийн үр дүн	-	(74,400.5)	(74,400.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,704,423.8	7,704,423.8	-
<b>Дүн</b>	<b>12,984,164.3</b>	<b>11,797,522.2</b>	<b>24,781,686.4</b>

Эх суралж: Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 6,314,289.9 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хургуулсан байна.

Сумын ИТХ-аас нийт зардал, эх үүсвэрийг 4,547,504.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 10 861 794 8 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

#### 3.5.2.1 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Бор-Өндөр сум нь аймгийн төсөвт олгох татаас 3,604,953.7 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 628,965.8 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр бүрэн олгогдсон байна.

Бор-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны орон нутгийн төсөв батлах тухай тогтоолд зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 7,202,379.3 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 8,190,935.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 988,556.0 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №8. Татварын орлогын гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Татварын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	<b>Татварын орлого</b>	<b>6,958,379.30</b>	<b>7,769,596.69</b>	<b>111.66</b>	<b>811,217.39</b>
2	Хувь хүний орлогын албан татвар	5,973,500.00	6,403,204.38	107.19	429,704.38
3	Үйл ажиллагааны орлого	258,889.30	426,497.35	164.74	167,608.05
4	Хөрөнгийн орлого	115,000.00	191,389.11	166.43	76,389.11
5	Хөрөнгө борлуусны орлого	90,000.00	153,544.34	170.60	63,544.34
6	Бууны албан татвар	1,500.00	1,590.00	106.00	90.00
7	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	226,990.00	285,226.77	125.66	58,236.77
8	Улсын тэмдэгтэйн хураамж	17,000.00	30,242.55	177.90	13,242.55
9	Малын тоо толгойн албан татвар	-	6,483.00	-	6,483.00
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	75,000.00	97,573.12	130.10	22,573.12
11	Газрын төлбөр	200,000.00	173,211.24	86.61	(26,788.77)
12	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;	500.00	634.84	126.97	134.84
	<b>Татварын бус орлого</b>	<b>244,000.00</b>	<b>421,338.64</b>	<b>172.68</b>	<b>177,338.64</b>
13	Торгуулийн орлого	168,000.00	77,096.68	45.89	(90,903.32)
14	Бусад орлого	76,000.00	344,241.96	452.95	268,241.96
	<b>НИЙТ</b>	<b>7,202,379.30</b>	<b>8,190,935.33</b>	<b>113.73</b>	<b>988,556.03</b>

Сумын төсвийн орлогын биелэлтэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого нөлөөлсөн бол газрын төлбөрийн орлого тасарсан байна.

#### 3.5.2.2 Төсвийн зарлага

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 24 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,525,311.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,276,084.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 886,099.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар, 363,163.7 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийг санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт зардлын 5,216,225.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 628,965.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 458,472.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 221,647.1 мянган төгрөг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 5,216,225.6 мянган төгрөг, ОНХС-аас 628,965.8 мянган төгрөг, нийт 5,845,191.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 328,795.1 мянган төгрөг тус тус санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,538,661.0 мянган төгрөг буюу 84.9 хувьтай байна. Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил цалин хөлс

болон нэмэгдэл урамшууллын зардал 91,313.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 15,291.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 26,134.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3,832.9 мянган төгрөг, нормативт зардал 885.1 мянган төгрөг, эд хогшил, ургал засварын зардал 1,182.2 мянган төгрөг, дотоод албан томилолт 3,210.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 99,248.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 78,366.2 мянган төгрөг, бусад ургал шилжүүлэг 5,818.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 298,202.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

### Хүснэгт №9. Хөтөлбөр арга, хэмжээний гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,633,467.00	1,413,188.89	220,278.11	86.51
2	80102 Туслах үйл ажиллагааны зардал	9,672.70	1,993.52	7,679.18	20.61
3	80106 Баг, хорооны УАЗардал	231,838.30	225,996.80	5,841.50	97.48
4	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол	1,374,538.30	1,352,736.10	21,802.20	98.41
5	80221 Гэрээт ажиллагадын зардал	366,406.40	366,406.40	-	100.00
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	59,255.50	53,436.87	5,818.63	90.18
7	80918 Бусад	132,800.00	132,300.00	500.00	99.62
8	81102 Орон нутгийн неөц хөрөнгө	82,900.00	82,437.47	462.54	99.44
9	81103 Эрсдэлийн сангийн неөц хөрөнгө	57,500.00	56,861.45	638.55	98.89
10	81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	363,163.70	-	363,163.70	-
11	81505 ИТХ-д суудалтай намуудад олгох	37,000.00	37,000.00	-	100.00
12	81518 Мерийн хөтөлбөрт тусгагдсан за	377,385.00	343,074.80	34,310.20	90.91
13	81701 Байгаль орчны хамгаалах, нөхөн	100,150.00	71,724.00	28,426.00	71.62
14	82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийл	27,725.00	27,698.22	26.78	99.90
15	82203 Нийтийн ззэмшилийн гудамж талбай	115,897.20	115,897.20	-	100.00
16	82204 Нийтийн ззэмшилийн гудамж талбайн	511,859.20	511,859.20	-	100.00
17	82210 Хотын доторх золбин муур, нохо	5,000.00	5,000.00	-	100.00
18	82211 Төвлөрсөн хогийн цэгүүдийн уст	72,582.10	72,582.10	-	100.00
19	82212 Хур хог хаягдал, орчны бохирдол	207,871.60	207,871.60	-	100.00
20	82801 Улсын их баяр наадам	5,000.00	5,000.00	-	100.00
21	83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох	615,930.80	452,724.10	163,206.70	73.50
22	83402 ОНХС - Хайгуулын тусгай	2,553.00	392.25	2,160.75	15.36
23	83403 ОНХС - Ашиглалтын тусгай				23.66
24	83406 ОНХС - Бусад	10,482.00	2,480.00	8,002.00	
	<b>НИЙТ</b>	<b>6,525,311.20</b>	<b>5,538,660.97</b>	<b>986,650.23</b>	<b>84.88</b>

Эх сурвалж: Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 287,569.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлснийг авч үзвэл Засаг даргын тамгын газар 253,079.6 мянган төгрөг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 12,352.7 мянган төгрөг, Соёлын төв 762.7 мянган төгрөг, Ерөнхий боловсролын сургуулиуд 41.9 мянган төгрөг, Хүүхдийн цэцэрлэгүүд 20,996.6 мянган төгрөг, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 0.1 мянган төгрөг, Хот тохижилтын газар 335.2 мянган төгрөг тус төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 743,309.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ажил төлөвлөснөөс “Гэрэлтүүлэг” 177,862.1 мянган төгрөг, “Хөл бөмбөгийн талбайн тохижилт” 19,411.7 мянган төгрөгийн төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүй бусад төсөл арга хэмжээнүүд 47.0-100 хувь хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бор-Өндөр сумын Засаг даргын нэмэлт дансанд дээд шатны төсвийн захирагчаас 178,859.8 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 633,762.6 мянган төгрөг нийт 812,622.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр хангамж бараа материалын зардалд 1,293.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 182,269.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 490,107.1 мянган төгрөг зарцуулж 138,952.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 2.6 Нэмэлт төсвийн тайланг

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 2.6.1 Нэмэлт төсвийн тайланг орлого

Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 2.6.2 Нэмэлт төсвийн тайланг зардлын зүйл

Тайлантай төсвийн тайланг зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Тайлантай төсвийн тайланг зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Тайлантай төсвийн тайланг зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Тайлантай төсвийн тайланг зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 2.6.3 Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Тайлантай төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэntий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хэntий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Хатанболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 75 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангаас нийт зардлын дүн 4,146,165.0 мянган төгрөгийн 1 хувь буюу 41,461.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 31,096.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч төсвийн шууд захирагчийн байгууллагад хамааралтай 29, төсвийн төвлөрүүлэн захирагчид хамааралтай 2 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй.

### 4.4 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бор-Өндөр сумын Засаг дарга нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсралын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсралын аудитын талаар

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсралын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 2 байгууллага, 1 төрийн сан, 3 тусгай сан, улсын төсвийн 8 байгууллагын тогтмол зардал нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад санал дүгнэлт гаргаж 9 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамруулан шалгаж 1 тусгай санг аудитад хамруулаагүй байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газарт аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж "Өөрчлөлтгүй", Мэргэжлийн боловсролын сургууль, Ерөнхий боловсролын Бор-Өндөр сургууль, Бор-Өндөр сумын нэгдсэн эмнэлэг "Платиниум прогресс аудит" ХХК аудит хийж "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт гаргасан байна.

### 5.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,162,984.2 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илэрснээс 1,142,711.0 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 6,326.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 13,946.8 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

#### Засаг даргын тамгын газар:

- ✓ Санхүүгийн тайлан дахь бараа материалын дансны эхний үлдэгдэл аудит хийгдсэн тайлангийн үлдэгдлээс 495.0 зөрүүтэй илэрхийлсэн алдааг залруулсан.
- ✓ Санхүүгийн тайлан дахь машин тоног төхөөрөмжийн дансны үлдэгдэл, бичиг хэргийн материалын үлдэгдэл, аж ахуйн материалын үлдэгдэл дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдлээс 2,858.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдааг залруулсан.
- ✓ Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан дахь ном санхүүгийн тайланд дахь ном дансны үлдэгдэл 445.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн алдааг залруулсан.
- ✓ Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан дахь барилга байгууламж дансны үлдэгдэл санхүүгийн тайланд 1,110,387.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн алдааг залруулсан.
- ✓ Тайлант онд ээлжийн амралтаа эдэлж байгаа ажилтнуудад 6,326.4 мянган төгрөгийн цалин бодож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ Нягтлан бодогчид балансын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 1,471.0 мянган төгрөг олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

#### Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- ✓ Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээрх хуримтлагдсан элэгдлийг санхүүгийн байдлын тайланд 3,607.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн алдааг залруулсан.
- ✓ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороодын үйл ажиллагааны зардалд 6,000.0 мянган төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 1,700.0 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Авлагын 1,833.8 мянган төгрөгийн үлдэгдэл тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### Хот тохижилтын газар:

- ✓ Үндсэн хөрөнгийн элэгдлийг 17,686.0 мянган төгрөгөөр дутуу байгуулсан алдааг залруулав.
- ✓ Нягтлан бодогчид балансын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,942.0 мянган төгрөг олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн

### Орон нутгийн хөгжлийн сан:

- ✓ Мөнгөн гүйлгээний тайландаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 7,231.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг залруулсан.

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 249,865.2 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрснээс 103,050.2 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 7,252.4 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 139,562.6 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага хүргүүлсэн байна.

### Аудитын илрүүлэлт:

Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

### Нэгдсэн эмнэлэг:

- ✓ Тайлант онд балансын урамшуулал даргад 3,242.0 мянган төгрөг, нягтлан бодогчид 2,942.0 мянган төгрөг, он дамжсан урамшуулал даргад 737.0 мянган төгрөг, "Оны шилдэг" 2 ажилтанд 2,486.0 мянган төгрөг, "Байгууллагын шилдэг" 4 ажилтанд 4,990.0 мянган төгрөг, дүн бүртгэгчид 801.9 мянган төгрөг, нийт 15,198.9 мянган төгрөгийн урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, зардлын ангилал зөрчин, төсвийн жил дамнуулан олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### Соёлын төв:

- ✓ "Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээрх хуримтлагдсан элэгдлийг санхүүгийн байдлын тайландаа 17,695.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн алдааг залруулсан.
- ✓ Үндсэн хөрөнгийн 1,999.5 мянган төгрөгийн элэгдэл бодоогүй алдааг залруулсан.
- ✓ Эзлжийн амралтын 2,674.5 мянган төгрөгийн олговрыг цалинтай давхардуулж олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ "Эзлжийн амралтын олговрыг 4 хоног илүү бодож олгосон 297.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### Бор-Өндөр сургууль:

- ✓ Тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын дүн мөнгөн гүйлгээний зардлын дүнгээс 68,355.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн алдааг залруулсан.
- ✓ Захирлын 2024 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Б/41 дүгээр тушаалаар 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр нягтлан бодогчид урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон, сургуулийн захирлын оны шилдгүүдийг шалгаруулж шагнах тухай Б/100 дугаар тушаалаар нийт 21 ажилтанд мөнгөн урамшууллыг зардлын ангилал зөрчин цалингийн сангаас олгосон, өндөр настны тэтгэврээ тогтоолгосон 3 багшид алба хаасан хугацааны нэмэгдэл, зэргийн нэмэгдлийг олгосон зэрэг 20,416.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### Оюуны уурхай бага сургууль:

- ✓ Урьдчилж төлсөн үйлчилгээний 15,000.0 мянган төгрөгийн төлбөрийг зардлаар хаасан алдааг залруулсан.

- ✓ Орон тооны жишиг нормативд тусгагдаагүй сургалтын менежер, архив бичиг хэргийн ажилтан, 2 бэлтгэгч, цахилгаанчин зэрэг 5 орон тоог илүү ажиллуулсан 87,134.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Байгууллагын шилдэг ажилтнуудыг цалингийн хувиар шагнаж урамшуулсан 6,691.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### Мэргэжлийн боловсролын сургууль:

- ✓ Тайлант онд 8 ажилтанд эзлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 4,086.4 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ Тайлант онд өглөг үүсгээгүй боловч "2023 оны шилдэг ажилтан"-аар 3 албан хаагчийн шалгаруулж, зардлын ангилал зөрчиж, цалингийн зардлаас 3,842.0 мянган төгрөгийн шагнал урамшуулалт олгосон, нягтлан бодогч, нярав нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн менген урамшууллыг тухай бүр олгосон боловч байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны А/35 дугаар д тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Өөрчлөлтгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нарт давхардуулан олгосон, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид Төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл цалин 194.5 төгрөгийг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 3-р цэцэрлэг:

- ✓ Тайлант оны эцэст 3,765.8 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайландаа хийсэн аудитаар 365,156.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 6,483.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 358,673.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

- ✓ Тайлант оны 6,483.0 мянган төгрөгийн малын тоо толгойн албан татварыг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Байхгүй

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- ✓ Тайлант онд орон нутгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын 21 төсөл арга хэмжээнд 774,210.6 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 20 төсөл арга хэмжээнд 572,678.4 мянган төгрөг зарцуулж, Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх 161,400.0 мянган төгрөгийн ажил хийгдээгүй буюу хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 79.2 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилттээр 743,309.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ажил төлөвлөснөөс "Гэрэлтүүлэг" 177,862.1 мянган төгрөг, "Хөл бөмбөгийн талбайн тохижилт" 19,411.7 мянган төгрөгийн төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд

хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- ✓ Хөрөнгө оруулалтаар хэрэгжих арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагад үндэслэн батлагдсан төсвийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдүүлсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хот тохижилт	1	17,685.98			1	17,685.98	1	17,685.98		
ЗДТГ	4	1,114,186.2			4	1,114,186.2	4	1,114,186.2		
ИТХ	1	3,607.80			1	3,607.80	1	3,607.80		
ОНХС	1	7,231.00	1	7,231.00			1	7,231.00		
ОН-ын байгууллагын дүн	7	1,142,711.0	1	7,231.00	6	1,135,480.0	7	1,142,711.0		
Бор-Өндөр сургууль	1	68,355.70	1	68,355.70		-	1	68,355.70		
Оюуны уурхай сургууль	1	15,000.00			1	15,000.00	1	15,000.00		
Соёлын төв	2	19,694.47			2	19,694.47	2	19,694.47		
УТ-ын байгууллагын дүн	4	103,050.17	1	68,355.70	3	34,694.47	4	103,050.17		
ДҮН	11	1,245,761.2	2	75,586.70	9	1,170,174.5	11	1,245,761.2		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хот тохижилт	1	2,942.00			1	2,942.00		
ЗДТГ	2	7,797.36	1	6,326.36	1	1,471.00		
ИТХ	3	9,533.83			3	9,533.83		
ОН-ын байгууллагын дүн	6	20,273.19	1	6,326.36	5	13,946.83		
МБС	3	10,635.93	2	4280.927	1	6,355.00		
З-р цэцэрлэг	1	3,765.80			1	3,765.80		
Бор-Өндөр сургууль	1	20,416.77			1	20,416.77		
Нэгдсэн эмнэлэг	1	15,198.90			1	15,198.90		
Соёлын төв	2	2,971.49	2	2971.492		-		
УТ-ын байгууллагын дүн	8	52,988.89	4	7,252.42	4	45,736.47		
ТТЗ	1	6,483.00	1	6,483.00				
ДҮН	14	73,262.07	5	13,578.78	9	59,683.30		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Оюуны уурхай сургууль	2	93,826.12			2	93,826.12		
УТ-ийн байгууллагын дүн	2	93,826.12			2	93,826.12		
ТТЗ	1	358,673.8					1	358,673.8
Нийт дүн	16	260,914.31	5	13,578.78	11	247,335.54	1	358,673.8



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 123-ХЭА-2025/006/НА-СТА-773  
A2370451 Чингис хот

Г

**Төлбөр барагдуулах тухай**

1

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын 6,483.0 мянган төгрөгийн орлогыг сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2. "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ", 60.2.8. "Малын тоо толгойн албан татварын орлого ..." гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоо" журмын 4.2.3.4.төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг жижигийн 4.2.3.4.төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Малын тоо толгойн албан татварын орлогын 6,483.0 мянган төгрөгийг Бор-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн Төрийн сан банк дахь 100182752400 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бор-Өндөр сумын Засаг дарга Г.Адъяабилэгт, санхүүгийн албаны дарга Э.Түвшинсайхан нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

..

Ж.ГАНБААТАР

Ц.ХАТАНБОЛД



• 232505123